



ХӨВСГӨЛ АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 06

Мөрөн

2018 оны төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “б” дахь заалт, “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 34 дүгээр зүйлийн 34.2.2, 57 дугаар зүйлийн 57.3, 64 дүгээр зүйлийн 64.1.2, 65 дугаар зүйлийн 65.1.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит IX хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн ээлжит V дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтын **1.2.12, 1.2.13, 1.2.14** дүгээр заалт мөн аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус IV дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын 05 дугаар хавсралтын **3.1, 3.4** дүгээр заалтуудад тус тус тусгагдсан арга хэмжээний зардлуудын санхүүжих дүнг хасах тодотголыг 1 дүгээр хавсралтаар, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас орлого буурсан Галт, Жаргалант, Тариалан, Цагааннуур, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдын 2018 оны жилийн батлагдсан цалин, НДШ-ийн төсөв хүрэлцэхгүй өр үүссэн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн дэмжлэгийг тус тус нэмэгдүүлэх тодотголыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 06 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.5 дахь заалтад тусгагдсан “Ренчинлхүмбэ сумын 4-р баг Жиглэгийн давааны 0,6 км хайрган хучилттай авто замын засварын ажил”-гэсний нэрийг “Хатгал тосгоны авто замыг засварлах ажил” -115,0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус 06 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралтын 8.1 дэх заалтын Хурд сааруулагч тавих ” Хатгал руу гарах камерын 2 талд, хилийн цэргийн ард” гэснийг “Шаардлагатай газарт хурд сааруулагч тавих” 3,0 сая төгрөг болгон тус тус өөрчлөн баталсугай.

3. Төсвийн тухай хуульд заасан зарчмын дагуу төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй, батлагдсан төсөвт багтаан орон тоо, цалинг тогтоон ажиллахыг тухайн сум, байгууллагын төсөв захирагч нарт даалгасугай.

4. Байгууллагуудын 2018 оны төсөвт санхүүгийн дэмжлэгийг тусган, сарын хуваарьт өөрчлөлт оруулан, мөрдөн ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д зөвшөөрсүгэй.


5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Төсөв, санхүү, эдийн засгийн хороонд даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2018 оны 12 дугаар сарын 05-ны  
өдрийн ээлжит IX хуралдааны  
06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт




Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар хэрэгжүүлэх  
хөтөлбөр, арга хэмжээний зардлын хасах тодотгол

/төгрөгөөр/

№	Заалтын дугаар	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих дүн	Тодотголоор хасах дүн
1. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017-12-04-ны өдрийн 06 дугаар тогтоолын 03 дугаар хавсралт						
1	1.2.12	Өрхийн эрүүл мэндийн төв барих тохижуулах ажил /Мөрөн сум/	2018-2018	150,000,000	100,000,000	100,000,000
2	1.2.13	Орон сууцны байруудын хэрэглээний халуун усны системд холбох	2018-2018	224,907,856	61,000,000	61,000,000
3	1.2.14	Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл барих	2018-2018	50,000,000	50,000,000	50,000,000
Дүн				424,907,856	211,000,000	211,000,000
2. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018-02-07-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 05 дугаар хавсралт						

4	3.1	Шинэ гудамж төсөл эхлүүлэх /Мөрөн сум/	2018- 2019	1,500,000,000	150,000,000	150,000,000
5	3.4	3 хүний халуун усны барилга /Алаг- Эрдэнэ сум/	2018- 2018	80,000,000	20,000,000	20,000,000
Дүн				1,580,000,000	170,000,000	170,000,000
Нийт дүн				2,004,907,856	381,000,000	381,000,000
Нийт эх үүсвэр:						381,000,000
Үүнээс:	Санхүүгийн дэмжлэгээс					211,000,000
	Аймгийн урьд оны үлдэгдлээс					170,000,000

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2018 оны 12 дугаар сарын 05-ны  
өдрийн ээлжит IX хуралдааны  
06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



Санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх тодотгол

/төгрөгөөр/

№	Сум, байгууллагын нэр	Цалин, НДШ-ийн зардалд
1	Галт	94,127,200
2	Жаргалант	84,077,600
3	Тариалан	71,708,300
4	Цагаан-Үүр	56,225,500
5	Чандмань-Өндөр	64,937,400
6	Эрдэнэбулган	51,314,400
7	Цагааннуур	31,819,800
8	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	16,789,800
<b>Зардлын дүн</b>		<b>471,000,000</b>
<b>Санхүүжих эх үүсвэр:</b>		<b>471,000,000</b>
1	Санхүүгийн дэмжлэг	211,000,000
2	Аймгийн урд оны үлдэгдлээс	260,000,000